



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ЦАГААН БУДААНЫ ЧАНАРТ ТАВИХ ТӨРИЙН ХЯНАЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Хүнс эвсэл, Байгаль орчны хуульчдын холбоо ТББ-ууд хамтран 2014-2015 онд “Цагаан будааны импорт, хэрэглэгчдийн аюулгүй, чанартай, баталгаат хүнс хэрэглэх эрхийг хэрэгжүүлэх төрийн хяналт”-д мониторинг хийлээ. Энэхүү мониторингоор цагаан будаа хилээр орж ирээд ямар шат дамжлагаар хэрэглэгчийн гарт хүрдэг, төрөөс тавьж буй хяналт шалгалт хэр үр нөлөөтэй байдаг, үүний дотор хүнд металл болон химийн бодисын бохирдол байгаа эсэхийг хэрхэн хянадаг, энэ талаар хэрэглэгчдэд үнэн бодитой мэдээлэл, анхааруулга өгөх тогтолцоо байгаа эсэхийг нягтлахыг зорилго. Мониторингид цагаан будаа импортлох, түгээх, борлуулахад оролцдог төрийн байгууллага, хүнсний бөөний төв, сүлжээ дэлгүүрийг хамруулж газар дээр нь тандалт ажиглалт хийх, дүрд тоглох, баримт бичигт дүн шинжилгээ хийх, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргуудыг ашиглав. Цагаан будааг сонгохдоо импортын хэмжээ, борлуулалт зэргийг харгалзаж үзсэн болно.

МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

Хүн амыг чанартай, тэжээллэг, аюулгүй хүнсээр хангах асуудлыг Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулиудаар тус тус баталгаажуулжээ. Мөн импортыг орлуулах хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх бодлого сүүлийн жилүүдэд эрчимтэй дэмжигдэн хэрэгжиж байгаа эхлэл байна. Гэсэн хэдий ч хүн амын хүнсний хэрэглээний 70 шахам хувийг импортолдог ба түүний дотор өргөн хэрэглээний хүнс болох цагаан будааг зөвхөн импортоор авдаг. Гэтэл цагаан будаанд агуулагдах хүнд металлын хүлцэж болох хэмжээг харьцуулах стандарт байхгүй байгаа нь анхаарал татах асуудал юм. Түүнчлэн жижиглэнгийн савлагаан дээр цагаан будааны гарал үүсэл, илчлэг чанар болон бусад шаардлагатай стандарт мэдээллийг дутуу хагас, эсвэл буруу зөрүү бичиж хэрэглэгчид тэрхүү мэдээллийг анзаарч, шалгаж сонгохгүй байгаа нь ажиглагдлаа. Мөн хяналт тавих эрх бүхий холбогдох төрийн болон үйлчилгээний байгууллагууд нь тус тусын хариуцах мэдээллийг нийтэд ил болгохгүй, хүсэлт гаргасан ч өгөх боломжгүй гэх хариулт өгч байгаа нь эдгээр байгууллагын ажилтнуудын чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны арга барилыг өөрчлөх шаардлагатайг харуулна. Мөн хүнс хил гаалиар орж ирэхээс эхлээд хэрэглэгчийн гар хүртэлх бүх үе шатанд төрийн хяналт шалгалт хийх чадавхыг сайжруулах, хэрэглэгчдийн хүнсний боловсрол мэдлэгийг тогтмол дээшлүүлэх, иргэний нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллагын хараат бус хяналт тавих, тайлан дүгнэлт гаргах нөхцөл боломж, чадавхыг бүрдүүлэх, эрх зүйн тогтвортой байдлыг баталгаажуулах шаардлагатай байна. Мониторингийн дүнг доор товчлон харуулав.

НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Манай улс цагаан будаагаа БНХАУ-аас голлон импортолдог бөгөөд 1995-2013 онд 80-аас дээш хувийг БНХАУ-аас импортолжээ.
2. Мониторингийн явцад ХХААЯ, ГЕГ /хуучнаар/, МХЕГ, ЭМСЯ, НМХГ зэрэг байгууллагаас чиг үүргийнх нь дагуу байх ёстой мэдээлэл хүсэхэд ихэнх тохиолдолд “манайд хамааралгүй”, “манайд байхгүй”, “тийшээ хандвал байж магадгүй”, “бид мэдэхгүй байна” гэсэн хариулт өгч байв. Энэ нь хүн амын

хүнсний хангамж, чанар, аюулгүй байдлын чиглэлээрх ажил нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй байгааг харуулахын зэрэгцээ төрийн холбогдох байгууллагууд байгаа мэдээллээ өгөх хүсэлгүй, хариуцлагагүй байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, МУ-ын хүн амын хүнсний чанар, шим тэжээллэг байдлыг - ЭМСЯ; аюулгүй байдал, хяналтыг – МХЕГ, Шадар сайд болон ГЕГ; хүртээмж, хангамжийг ХХААЯ хариуцаж байна.

3. Хүнсний тухай хуулиар 2013 оны 3 сарын 1-ээс эхлэн хувь хүмүүс хүнсний үйлчилгээ, худалдаа эрхлэхийг хориглосон хэдий ч цагаан будааг бөөний төв, захууд дээр хувь хүмүүс бөөндөж худалддаг байдал хэвээр байна.
4. ГЕГ-ын мэдээлснээр цагаан будаа нийт 13 боомтоор орж ирж байгаа тул дор хаяж мэргэжлийн хяналтын 13 улсын байцаагчийн дүгнэлт байх ёстой. Гэтэл ердөө нэг боомтын улсын байцаагчийн дүгнэлтийг хувилан хүнсний захуудын ихэнх худалдаачид үзүүлж байлаа.
5. Импортын цагаан будаанд Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар тус тус тогтоосон хяналт шалгалтыг Шадар сайдын 2014 оны Эдийн засгийг эрчимжүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх зорилго бүхий 233, 60-р тушаалаар дордуулж, сулруулжээ. Тухайлбал, 2012 оны Хүнсний тухай хуулиар үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний барааг импортлох бүртээ барааны дээжийг шинжлүүлэн импортын мэдэгдэл авдаг байжээ. Харин Шадар сайдын дээрх шийдвэрээр нэг импортын мэдэгдэл аваад 6 сарын хугацаанд хэдэн ч удаа уг барааг импортолж болохоор зохицуулсан байна.
6. Хүнсний тухай хуулийн 12-р зүйлийн 12.1-д хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд,

бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцах тухай заасан байдаг ч энэ заалт хэрэгжихгүй байна. Тухайлбал, цагаан будаа импортлогч болон худалдан борлуулагч нь хаанаас, ямар компаниас будаа авсан, хэзээ хэнд, хэдий хэмжээний борлуулалт, нийлүүлэлт хийсэн бүртгэл хөтөлдөггүй, түүнд тавих хяналт шалгалт ч хийгддэггүй байна.

7. Хүнсний тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.4-д зааснаар хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, нээлттэй байх ёстой. Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэлд дурдсанаар 2013 онд таван улсаас 59,3 тн цагаан будаа импортын мэдүүлэггүй, өөрөөр хэлбэл шинжилгээ хийлгэлгүй оруулжээ. Энэ талаар ГЕГ-аас мэдээлэл хүсэхэд өгөх боломжгүй гэсэн бөгөөд энэ нь Хүнсний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг тус тус зөрчсөн үйлдэл юм.
8. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.1-ийн “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр; үйлдвэрлэгчийн нэр, хаяг; хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар; үйлдвэрлэсэн он, сар, өдөр; хадгалах хугацааг заасан байх” тухай заалтыг савлах эрх авсан ААН-үүд хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, НМХГ-аас жижиглэнгээр савлах зөвшөөрөл авсан Агь Импекс ХХК нь БНХАУ-аас импортолсон будааг Сакура (2кг-ын үнэ 7520₮) нэрээр савлаж, уутан дээр нь БНХАУ, Liaoning муж, Chaoyang хот, “Hong –Xu Agriculture&Forestry Product Processing” компани; Слава (2кг-ын үнэ 6690₮) нэрээр савлаж уутан дээр БНХАУ, Hei Long Ji-ang муж, Huling хот, “Shuang Feng Mi” гэж өөр өөр мэдээлэл тавьжээ. Булган өгөөж ХХК нь мөн БНХАУ-аас импортолсон будааг Жифи, Сувдан сондор нэрээр савлаж, уутан дээр нь БНХАУ гэснээс өөр ямар ч мэдээлэл тавиагүй байна. Үүний зэрэгцээ жижиглэнгээр савладаг ААН-үүд уут саваа нэг удаад олноор хэвлэдэг тул будаагаа өөрчлөхөд шошгын мэдээллээ шинэчилдэггүй ажээ.

ХОЁР. ИМПОРТЫН ХҮНСНИЙ СТАНДАРТ БОЛОН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭ

1. MNS 4504:2008 стандартад хүнсний зарим бүтээгдэхүүнд агуулагдах хар тугалгын хүлцэж болох хэмжээг заасан байна. Тухайлбал, үр жимст хүнсний ногоо, үрт ургамал, зарим нөөшилсөн, хатаасан жимс, жимсгэнэ, тэжээвэр шувууны мах, хүүхдийн тэжээл, хоолны давс, дарс зэрэг 60 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хар тугалгын хүлцэж

болох хэмжээг заажээ. Энэ жагсаалтад цагаан будаа ороогүй бөгөөд бусад хүнсэнд хүнд металлын хэмжээг шалгах арга, стандартаар тодорхойлж байна.

2. УМЭ, УМХЕГ-ын итгэмжлэгдсэн лабораториуд аргын стандартыг хэрэглэж хүнд металлын агуулгыг тодорхойлохдоо өөр өөр нэгжээр гаргаж хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна.

3. МХЕГ-ын лаборатори цагаан будааг шинжлүүлэх үед дээжээ өгч, мөнгө төлөөд болно гэсэн хэдий ч шинжилгээ хийх дээж авахад МХГ-ын улсын байцаагч оролцоогүй гэсэн шалтгаанаар дүгнэлт гаргахаас татгалзсан нь хариуцлагагүй үйлдэл юм. Хэрэв МХГ-ын байцаагч оролцоогүй гэсэн үндэслэлээр шинжилгээний дүнд дүгнэлт өгөхөөс татгалзах журамтай бол анх шинжилгээ хийхээр дээж авахдаа энэ тухай мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгөх ёстой билээ.
4. МУИС-ийн Хүрээлэн буй орчин судлалын лабораторийн шинжилгээний дүнгээр дөрвөн өөр савалгаатай цагаан будаанд агуулагдах хар тугалга болон кадмийн хэмжээ нөгөө хоёр лабораторийн дүнтэй харьцуулахад өндөр гарсан хэдий ч стандарт хэмжээнээс хэтрээгүй гэсэн дүгнэлт өгсөн. Гэвч энэ лаборатори хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх магадлан итгэмжлэлгүй учир дүгнэлтийг албан ёсоор хүлээн зөвшөөрөхгүй.
5. Мониторингоор нэг төрлийн будааг гурван өөр лабораторид өгсөн ч хүнд металлын агууламж өөр өөр гарсан нь эргэлзээ төрүүлж байгаа юм.
6. Мөн хараат бус магадлан итгэмжлэгдсэн лаборатори байхгүй /хараат бус магадлан шинжилгээний дүнгээр баталгаажуулах үүрэг бүхий/ байна гэж дүгнэлээ.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭ

1. Хэрэглэгчдийн хүнсний эрхийн мэдлэг хангалтгүй, энэ талаар мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа хийгдэхгүй байна. Тухайлбал, хэрэглэгчид цагаан будааг сонгохдоо зөвхөн жижиглэнгээр савлагдсан үеийн оноосон нэр (Сакура, Слава, Фүжи гэх мэт), үнэ (ижилхэн 2 кг-аар савлагдсан бол арай ахиу үнэтэйг сайн гэж ойлгох) гэсэн хоёр шалгуураар сонгодог байна. Хэрэглэгчид цагаан будааг сонгохдоо 100 гр будаанд агуулагдах тэжээллэг чанар, орц, найрлага; мөн үйлдвэрлэгчийн нэр, хаяг; хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар; үйлдвэрлэсэн он, сар, өдөр; хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа зэрэг нарийн үзүүлэлттэй танилцаад шаардлагатай тохиолдолд худалдагчаас дэлгэрэнгүй мэдээлэл авч сонголтоо хийх учиртай ч мониторингийн явцад ийм байдал огт ажиглагдсангүй. Үүний зэрэгцээ зарим байгаа мэдээлэл нь эх хэл дээр бичигдээгүй, эсхүл бүрэн гүйцэд унших боломжгүй байна.
2. БНХАУ-аас гарал үүсэлтэй будааг Япон, ОХУ, БНСУ-ын бэлэгдэл болсон Фүжи, Слава, Сакура зэрэг нэрээр савлан худалдаж иргэдийг төөрөгдүүлж байна. Хэдийгээр савлагааны шошгон дээр БНХАУ гэсэн бичиг байгаа хэдий ч хэрэглэгчдийн мэдлэггүй, хайнга байдлыг зориуд ашиглаж төөрөгдүүлж байна гэж үзлээ.
3. Хүн амын хүнсний эрхийн хэрэгжилт, хүнсний хангамж, чанар, баталгааны талаар төрөөс хийсэн тайлан, судалгааны ажил хомс байв. Түүнчлэн статистик мэдээлэл ч мөн хомс бөгөөд 2010 онд Тагнуулын ерөнхий газрын хийсэн тайлан мэдээлэл л гол эх сурвалж болов. Хүнс, хүнсний бүтээгдэхүүний импорт давамгайлсан, хувиргасан амьд организм бүхий хүнс ихээр үйлдвэрлэгдэх болсон энэ цаг үед импортын хүнсний аюулгүй, тэжээллэг, баталгаат байдалд хийсэн хөндлөнгийн судалгаа, тайлан мэдээлэл ховор байгаа нь анхаарал татаж байна.

ЗӨВЛӨМЖ

Мониторингийн үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Эрх зүйн орчин, хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэжлийн хяналт шалгалтыг сайжруулах

1. Импортын хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг хязгаарлах, дотооддоо үйлдвэрлэх талаар авч буй хүчин чармайлтаа тогтвортойгоор нэмэгдүүлэх хүрээнд эрх зүйн орчноо сайжруулах;
2. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн яам нь хүнсний бүтээгдэхүүний хангамж, чанар, аюулгүй байдлын талаарх бодлогоо эрчимжүүлэх, бусад холбогдох яамдтай уялдаа холбоогоо сайжруулж нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж, энэ чиглэлийн мэдээллийг нэгтгэдэг улмаар тогтмол хугацаанд дүгнэн боловсруулж олон нийтэд мэдээлдэг эрх зүйн орчин, тогтолцоог бий болгох;
3. Импортын цагаан будаагаар хязгаарлахгүй импортын бүх хүнс, хүнсний бүтээгдэхүүнд тавих төрийн хяналтыг сайжруулах, тухайлбал, импортын хүнсэнд зөвхөн гаалиар орж ирэх үеийн болон хорио цээрийн хяналтаас гадна хилийн гүнд орж ирсний дараагийн үйл

ажиллагаа болох савлах, тээвэрлэх, хадгалах үе шат бүрт тавигдах үр дүнтэй хяналтыг тогтмолжуулах бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

- Импортлогч хуулийн этгээд импортолсон будааны гарал үүсэл, баталгаат байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд таниулан мэдээлэх үүрэг хариуцлагын тогтолцоо бий болгох;
- Улс орны эдийн засгийн хүндрэл, санхүүгийн хямрал нэрээр урьд байсан хуулийн зохих заалтуудыг алга болгох, сулруулах зэргээр дордуулж, угаас хяналтын чадавх хангалтгүй сул байгаа импортын хүнс, хүнсний бүтээгдэхүүн түүнийг импортлогчдод тавьж буй хяналтыг улам сулруулсан Шадар сайдын 2014 оны 60, 233-р тушаалуудыг эргэн харж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүнсний тухай хууль тогтоомжид нийцүүлэх, импортын хүнсэнд тавих төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, тогтвортой байлгах;
- Хүнсний сүлжээнд оролцогчдын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хэрэглэгчдээр үнэлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- МХЕГ нь олгож байгаа импортын мэдэгдлийг импортын гэрчилгээний хамт; ГЕГ нь хилийн аль боомтоор, хэзээ, ямар компани, аль улсаас, хэдий хэмжээний цагаан будааг, ямар тээврийн хэрэгслээр, ямар савлагаатай оруулж ирсэн талаарх мэдээллийг тус тус улирал бүр цахим хуудастаа байршуулах замаар ил тод болгох;
- Хүнсний тухай хуулиар савлагаан дээр 100 гр цагаан будаанд агуулагдах уураг, тос, нүүрс, илчлэг зэрэг мэдээллийг бичих заалтыг савлах эрх авсан ААН-үүдэд мөрдүүлэх;
- НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллагын хүнсний тусгай илтгэгчийг урьж ажиллуулах.

Хоёр. Импортын хүнсний стандарт болон лабораториудын үйл ажиллагааг сайжруулах

- MNS 4504:2008 стандартад цагаан будаанд агуулагдах хүнд металлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг нэмж тусгах;
- Магадлан итгэмжлэгдсэн лабораториуд цагаан будаанд агуулагдах хүнд металлын хүлцэж

болох хэмжээг тодорхойлохдоо адил нэгж ашиглах;

- Олон нийтэд үйлчлэх статустай лабораториуд хэрэглэгчдэд хямд үнээр шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх; баталгаатай, үнэн бодитой мэдээлэл өгдөг байх эрх зүйн зохицуулалт, тогтолцоог бий болгох;
- МХГ-ын байцаагч байхгүй тохиолдолд дээжид шинжилгээ хийхгүй байх, МХЕГ нь шинжилгээний дээж хүлээн авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах талаарх эрх зүйн баримт бичгүүдийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх;
- МХЕГ-ын үндэсний лаборатори импортын хүнсний дээжид хийсэн шинжилгээний дүн, түүнд улсын байцаагчийн хийсэн дүгнэлтийг МХЕГ-ын цахим хуудаст ил тод нээлттэй байршуулах;
- ОУ-ын түвшинд хараат бус итгэмжлэгдээгүй лабораторийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрдөгтэй адил манай улсад сургалт, эрдэм шинжилгээний лабораторийн гаргасан шинжилгээний дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, мэдээллийг олон нийтэд тогтмол нээлттэй байлгах эрх зүйн зохицуулалт, тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх.

Гурав. Хэрэглэгчдийн мэдээлэл авах эрхийг хангах, хяналт тавих боломжийг хангах

- Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хүнсний асуудлаар шинжлэх ухаанд суурилсан ойлголт, мэдлэг олгох, хүнсний бүтээгдэхүүний тухай бодит мэдээлэл түгээх нэвтрүүлгийн тогтмол цагтай болох;
- Хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг жижиглэнгээр савлаж нэрлэхдээ иргэдийг хуурах, төөрөгдүүлэхгүй байх үүргийг хуульчилсан эрх зүйн орчныг бий болгож хэрэглэгчдийн хүнсний болон үнэн бодит мэдээлэл авах эрхийг хуульчлан баталгаажуулах;
- ХХААЯ, ЭМЯ, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хамтран хүнсний чанар, тэжээллэг байдал, аюулгүй байдлын баталгаа, үнийн өсөлт, төрийн хяналт шалгалтын хэрэгжилтэд дүгнэлт хийж, жил бүр тайлан гаргах.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдал амьдралд хэр бодитой хэрэгжиж байгаад төрийн бус байгууллага (ТББ)-ууд мониторинг хийдэг билээ. Мониторингийн гол үр дүнг энэхүү МОНИТОР цувралаар олон нийтэд хүргэхийн сацуу төрийн үйлчилгээг цаашид боловсронгуй болгох чиглэлээр мониторинг хийсэн байгууллагууд нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг юм.

Жамьян гүний гудамж -5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48,
Утас: (976-11) 313207, Факс: (976-11) 324857